



**ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ**

2021 оны 11 сарын 04 өдөр

Дугаар А/14

Эрдэнэт

Тайлан баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.4, 29 дүгээр зүйлийн 29.4 дэх хэсэг, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2018 оны А/207 дугаар тушаалаар баталсан "Аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх бүрэн эрх"-ийн 2.4 дэх хэсэг, "Төрийн аудитын байгууллагын аудит хийх журам"-ын 18.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр нөлөө" гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагыг хавсралтаар баталсугай.
3. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын гуравдугаар газар, аймгийн Засаг даргад хүргүүлсүгэй.
4. Аудитын тайланд дурдагдсан зөрчлүүдийг арилгахаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2022 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга /С.Батжаргал/-д зөвлөсүгэй.
5. Аудитын тайлангаар өгсөн албан шаардлага, тогтоосон төлбөрийн актын хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2022 оны 2 дугаар улиралд гарган танилцуулахыг аудитын менежер /Б.Эрдэнэ/, ахлах аудитор /В.Жавзмаа/, аудитор /Б.Бямбаатогтох/ нарт даалгасугай.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРМАНДАХ

Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын
дарга, Тэргүүлэх аудиторын 2021 оны 11
дүгээр сарын 04-ний өдрийн А/14 дүгээр
тушаалын хавсралт

Аудитаар тогтоосон төлбөрийн акт, албан шаардлагын жагсаалт

6117143690
0440073 9042806

№	Алдаа зөрчлийн товч утга	Акт, албан шаардлагын дугаар	Хариуцагч байгууллага	Мөнгөн дүн /сая.төгрөг/
1	Өрхийн тариалалтын дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд олгосон 12 хүлэмжийн үнийн дүнгийн 50 хувийг орон нутгийн дансанд төвлөрүүлээгүй.	05/65 ОРА-2021/14-13-ШТА-ГА	ХХААГ	14.7
2	"Өрхийн тариалалтыг дэмжих дэд хөтөлбөр"-ын хүрээнд 19 өрхөд хүлэмжийг шийдвэргүйгээр олгосон байна.	10/116 ОРА-2021/14-13-ШТА-ГА	ХХААГ	47.8
Нийт дүн				62.5



ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

**ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХАНГАХ ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧНЫГ
САЙЖРУУЛЖ, ЧАНАРТАЙ, ШИМ
ТЭЖЭЭЛЛЭГ ХҮНСЭЭР ТОГТВОРТОЙ
ХАНГАХ, ХҮН АМД ХҮНСНИЙ
ХЭРЭГЛЭЭ, ЗӨВ ДАДЛЫГ
ХЭВШҮҮЛЭХЭД АНХААРЧ,
ХЯНАЛТЫГ САЙЖРУУЛАХ
ШААРДЛАГАТАЙ БОЛСОН БАЙНА.**

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХҮНСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫГ
ХЯНАХ ӨНӨӨГИЙН ТОГТОЛЦОО,
ТӨСВӨӨС ЗАРЦУУЛСАН ХӨРӨНГИЙН
ҮР ДҮН**

2021 оны 11 дүгээр сар

АГУУЛГА

Товчилсон үгийн тайлбар	5
Хүснэгтийн товъёг	6
Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл	7
БҮЛЭГ 1. Хүнсний аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг сайжруулж, шим тэжээллэг хүнсээр тогтвортой хангах, хүн амд хүнсний хэрэглээ, зөв дадлыг хэвшүүлэхэд анхаарах шаардлагатай байна.	9
<i>А.1. Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогын зорилт бүрэн хангагдахгүй, зарим арга хэмжээ болон хууль, эрх зүйн зохицуулалт бүрэн хэрэгжихгүй байгаад анхаарахаар болсон байна.</i>	9
<i>А.2 Хүнсний аюулгүй байдлын бодлого, арга хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянах байгууллагуудын бүтэц, чиг үүргийг тодорхой болгож, ажлын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.</i>	13
<i>А.3 Хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан чанарын стандартыг мөрдсөн, олон улсын жишигт нийцсэн эрүүл, шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой хангахад анхаарахаар болсон байна.</i>	15
БҮЛЭГ 2. Хүнсний аюулгүй байдлыг хангахад төсвөөс зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүйгээс зориулалт бусаар зарцуулж, төвлөрүүлэх орлогыг төвлөрүүлээгүй байна.	22
<i>Б.1 Төсвийг үр ашигтай төлөвлөсөн байна.</i>	22
<i>Б.2 Төсвийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлд хяналт хэрэгжээгүй байна.</i>	22
ДҮГНЭЛТ:	24
Холбогдох байгууллагын санал:	26
ХАВСРАЛТУУД:	27

Товчилсон үгийн тайлбар

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
БНХАУ	Бүгд найрамдах хятад ард улс
БНСУ	Бүгд найрамдах солонгос улс
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сан
ЗГХЭГ	Засгийн газрын хэрэг эрхлэх газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МХГ	Мэргэжлийн хяналтын газар
МЭГ	Мал эмнэлгийн газар
ОБГ	Онцгой байдлын газар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ӨЭМТ	Өрхийн эрүүл мэндийн төв
СХАА	Санхүү хяналт, аудитын алба
СХЗГ	Стандартчилал, хэмжил зүйн газар
ТББ	Төрийн бус байгууллага
ТӨҮГ	Төрийн өмчит үйлдвэрийн газар
УИХ	Улсын Их Хурал
ХАҮТ	Худалдаа, аж үйлдвэрийн танхим
ХХААГ	Хүнс, хөдөө аж ахуйн газар
ХОХБТХ	Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХШҮДАХ	Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтэс
ҮАГ	Үндэсний аудитын газар
ЭМГ	Эрүүл мэндийн газар

Хүснэгтийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Аймгийн лабораториудын хүчин чадал, хангамжийн судалгаа	14
Хүснэгт 2	Аймгийн лабораториудын шинжилгээ, үзүүлэлтийн судалгаа	15
Хүснэгт 3	Аймгийн хүнсний үйлдвэрлэлийн тоо, хүчин чадал ашиглалт /тоогоор, хувиар/	15

Дүрслэлийн товъёг

№	Тайлбар	Хуудасны дугаар
Дүрслэл 1	Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хүнсний салбарын стандарт	8
Дүрслэл 2	Сав, баглаа боодлын болон хүнсний технологийн стандартуудын баталсан он цагийн дараалал	9
Дүрслэл 3	Үндэсний хөтөлбөр, аймгийн дэд хөтөлбөрийн биелэлт	10
Дүрслэл 4	Хүнсээр дамжин хүний эрүүл мэндэд учирсан хохирол буюу хоолны хордлогын үзүүлэлт	12

Аудит хийх үндэслэл, бүрэн эрх	Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2020 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 05 дугаар тогтоолоор баталсан Үндэсний аудитын газраас гүйцэтгэх аудитын сэдвийг үндэслэн “Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн”-д аудит хийлээ.
Аудитын зорилт	Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүнд улсын хэмжээнд нэгдсэн удирдамжаар гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж, Улсын Их Хурал болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн. Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: • Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо үр нөлөөтэй байгаа эсэх; • Хүнсний аюулгүй байдлыг хангахад төсвөөс зарцуулсан хөрөнгө үр дүнтэй байгаа эсэх;
Аудитын хамарсан хүрээ	Аудитад аймгийн ЗДТГ, аймгийн МХГ, ХХААГ, МЭГ, ЭМГ, сумдын ЗДТГ, хүнсний сүлжээний үе шатанд оролцогч хуулийн этгээд, иргэдийн аудитад хамаарал бүхий үйл ажиллагааг хамрууллаа.
Аудитын хязгаарлалт	Аудитын хязгаарлалт үүсээгүй болно.
Аудитын арга зүй, шалгуур үзүүлэлт	Аудитыг гүйцэтгэхэд АДБОУС 100, 300, 3000, тэдгээрт нийцүүлэн баталсан Монгол Улсын Төрийн аудитын стандарт MNS 6817-1:2020 “Төрийн аудит. Тулгуур зарчим”, MNS 6817-5:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудитын тулгуур зарчим”, MNS 6817-7:2020 “Төрийн аудит. Гүйцэтгэлийн аудит” стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дүгээр тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-ыг ашиглан, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон аудитын горимын дагуу нотлох зүйл цуглуулж, холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга авах, судалгаанд тулгуурлан дүн шинжилгээ хийж, аудитын хөтөлбөр, горим, асуудлын шинжилгээний дагуу нотлох зүйл цуглуулж, аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж боловсруулав.

**Аудитын
бүрэлдэхүүн,
хугацаа**

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Нармандах удирдаж, аудитын менежер Б.Эрдэнэ чанарын хяналтыг хэрэгжүүлж, ахлах аудитор В.Жавзмаа, аудитор Б.Бямбатогтох нар гүйцэтгэв. Аудитыг 2021 оны 08 дугаар сарын 31-ний өдрөөс 2021 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр хүртэл хийж гүйцэтгэж, аудитын тайланг холбогдох үе шатны хяналтаар хянуулан Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаалаар баталгаажуулж, 2021 оны 11 дүгээр сарын 05-нд ЯАГ-т хүргүүллээ.

**Хүндрэл
бэрхшээл**

Коронавируст халдварын цар тахалтай тэмцэх хариу арга хэмжээг эрчимжүүлэх, урьдчилан сэргийлэх зорилгоор улсын хэмжээнд засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, иргэн, хуулийн этгээдийг гамшгаас хамгаалах бүх нийтийн өндөржүүлсэн болон бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбоотойгоор аймгийн Засаг даргын харьяа хэлтэс, албад, албан тушаалтан, хүнсний үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж байгууллага, иргэдтэй уулзах, үйл ажиллагаатай танилцах, баримт материал авахад цаг хугацааны хувьд хүндрэл үүссэн болно.

Ерөнхий мэдээлэл:

Орхон аймгийн хэмжээнд тухайн хүнсний бүтээгдэхүүний жилийн нийт нөөцийг жишсэн хүн амын хүнсний жилийн хэрэгцээнд харьцуулснаар тодорхойлж байгаа бөгөөд жилийн эцсийн суурин хүн амын тоо 2019 онд 104,032, жишсэн хүн амын тоо 82,381 байна. 2020 онд суурин хүн амын тоо 105,361, жишсэн хүн амын тоо 84,110 болжээ.

Манай аймгийн хүн амын хүнсний гол нэрийн 16 бүтээгдэхүүний зохистой хэрэгцээг 2020 оны байдлаар тооцож үзвэл, жилд нийтдээ 3.7 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 4.9 мянган тонн сүү, сүүн бүтээгдэхүүн, 3.0 мянган тонн гурил, 5.5 мянган тонн гурилан бүтээгдэхүүн, 1.5 тонн будаа, 1.0 мянган тонн сахар, чихрийн зүйл, 3.6 мянган тонн төмс, 7.9 мянган тонн хүнсний ногоо, 1.2 мянган тонн буурцагт ургамал, 6.1 мянган тонн жимс, жимсгэнэ, 0.6 мянган тонн өндөг, 0.7 мянган тонн ургамлын тос, 0.3 мянган тонн цөцгийн тосны хэрэгцээтэй байна.

Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн мах, махан бүтээгдэхүүнээр 85.6 хувь, төмсөөр 100.0 хувь, хүнсний ногоогоор 53.0 хувийг хангаж байна. Аймагт хүнсний үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн 85 бүртгэлтэйгээс 2020 онд 39 буюу 45.9 хувь нь үйл ажиллагаа явуулжээ. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбараар авч үзвэл сүү, сүүн бүтээгдэхүүн, үр тарианы үйлдвэрлэл хангалтгүй, бүрэн хүчин чадлын 10 хүртэл хувийг ашиглаж байна.

БҮЛЭГ 1. Хүнсний аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг сайжруулж, шим тэжээллэг хүнсээр тогтвортой хангах, хүн амд хүнсний хэрэглээ, зөв дадлыг хэвшүүлэхэд анхаарах шаардлагатай байна.

А.1. Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогын зорилт бүрэн хангагдахгүй, зарим арга хэмжээ болон хууль, эрх зүйн зохицуулалт бүрэн хэрэгжихгүй байгаад анхаарахаар болсон байна.

А.1.1.1 Төрөөс батлан хэрэгжүүлсэн хөтөлбөрүүдийг уялдаатай, үр дүнг тооцох боломжгүй төлөвлөснөөс зорилт бүрэн хангагдаагүй, зарим арга хэмжээ тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Хүнсний аюулгүй байдал нь Үндэсний аюулгүй байдлын чухал хэсэг бөгөөд “Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал нь үндэсний аюулгүй байдлын талаарх төрийн бодлогын нэгдмэл, залгамж чанарын үндэс болно” гэж заасан бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого, Хүнсний тухай, Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулиар хуульчилжээ.

Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого хоорондоо уялдаатай байх боловч үндэсний хөтөлбөрүүдээс 2 нь аймагт удирдлага, зохион байгуулалтыг хэн хариуцах нь тодорхойгүй, 2 нь дэд хөтөлбөр баталж хэрэгжүүлэхээр, хэрэгжилт үр өгөөжийг тооцох бүрэн боломжгүй, эх үүсвэргүй, зарим хөтөлбөрүүдийн агуулга давхацсан хөтөлбөрүүд баталсан байна. Иймд салбарын бүс нутаг бүрийн онцлогт тохирсон, хэрэгжилт, үр өгөөжийг тооцох боломжтой, хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

УИХ-аас баталсан бодлого, үндэсний хөтөлбөрүүдийн зорилт Орхон аймагт бүрэн хангагдаагүй, зарим арга хэмжээ тодорхой үр дүнд хүрээгүй байна.

Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт “Эрүүл хүнс, цэвэр орчинтой – Аз жаргалтай иргэд, Эрдэнэтийн хэрэгцээг эрдэнэтчүүд хангана” гэсэн зорилго тавьж, 11 зорилтын хүрээнд 37 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж, эдгээрийг хэрэгжүүлэх чиглэлээр 2 дэд хөтөлбөр, “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх II үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэсний хөтөлбөрүүдтэй нийцүүлэн баталжээ. Аймгийн Засаг даргын 2016-2020 оны мөрийн хөтөлбөрийн биелэлтийг 98.5 хувь хэрэгжүүлсэн гэж үнэлсэн байна.

Үндэсний болон дэд хөтөлбөр хэрэгжсэнээр аймагт дараах үр дүн гарчээ. Үүнд:

- төмс, хүнсний ногоо тариалалт 3-12.6%, ургац хураалт 16-41%-аар өссөн.
- жимс, жимсгэнэ тариалдаг иргэд, аж ахуйн нэгжийн тоо нэмэгдэж, нэр төрөл олширч, суулгац орон нутагт үржүүлдэг болсон.
- хүлэмжийн аж ахуй эрхлэгчийн тоо нэмэгдэж, тариалалт нэмэгдэж, ургац хураалт өссөн.
- паразит өвчнөөр өвчилсөн мал амьтдын тоо буурсан.
- боловсруулах хүнсний үйлдвэрлэлийн хэмжээ нэмэгдсэн.
- мал эмнэлэг, үйлчилгээний нэгжүүдийн тоног төхөөрөмж, багаж хэрэгслээр хангагдсан.

Үндэсний болон дэд хөтөлбөр хэрэгжсэн ч тодорхой үр нөлөөнд хүрээгүй, хэрэгжээгүй арга хэмжээнүүд байна. Үүнд:

- Мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, экспорт, импорт, хүн амын хүнсний хэрэглээний нэгдсэн мэдээллийн сан, сүлжээ бий болоогүй, хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлттэй холбоогүй байна.

- Сав, баглаа боодлын үйлдвэр цөөн, өртөг өндөр учир импортын сав, баглаа боодол ашигласаар байна.
- Орон нутгийн түвшний хүнсний аюулгүй байдлын лабораториудын чадавхыг сайжруулаагүй, итгэмжлэлийн хүрээг өргөтгөөгүй, олон улсын итгэмжлэлд хамруулаагүй байна.
- Хүнсний салбарын зарим техникийн зохицуулалт, үндэсний стандартыг шинээр боловсруулж батлуулаагүй байна.

Иймд хөтөлбөр баталж хэрэгжүүлэхдээ салбар, орон нутгийн онцлогт тохируулан, арга хэмжээ бүрээр үр дүнг тооцох боломжтой, тодорхой ахиц, дэвшил гарч, иргэдэд үр нөлөө өгдөг, зорилт бүрэн хангагдах боломжтой байдлыг судалгаанд үндэслэж байх шаардлагатай байна.

А.1.1.2 Хүнсний салбарт мөрдөгдөж буй зарим стандартуудыг шинэчлэх, шинээр батлах шаардлага үүссэн байна.

Стандартчилал нь бүтээгдэхүүний хэрэглээний нийцтэй байдал, харилцан орлуулалт болон сорилт, хэмжилтийн нэгдмэл байдлыг хангах замаар нөөцийг зүй зохистой ашиглах, бүтээгдэхүүний өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, худалдааг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, техникийн зохицуулалт нь хүний эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчин, бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн аюулгүй байдлыг хангах, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах зорилготой байна.

Монгол Улсад өнөөдрийн байдлаар 6675 стандарт, 8 техникийн зохицуулалт хүчин төгөлдөр мөрдөж байна. Хүнсний технологийн 606 стандарт, 5 техникийн зохицуулалт байна. Эдгээрээс 330 нь шинжилгээний арга, аргачлалын стандартууд, 172 нь хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний техникийн ерөнхий шаардлагын талаарх стандартууд, 104 нь хүнсний үйлдвэрийн нийтлэг асуудал, тоног төхөөрөмж, бусад стандартууд байх ба технологийн нэр төрлөөр харуулбал дараах байдалтай байна.


Дүрслэл 1. Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж буй хүнсний салбарын стандарт /тоогоор/



Хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, тээвэрлэлтэд хамааралтай барааны сав, баглаа, боодол ба хуваарилалтын 41 стандарт мөрдөж байна.

Хүнсний технологи болон сав баглаа боодлын стандартуудын 73-75 хувийг 2010 оноос өмнө баталсан байгаа нь үйлдвэрлэх бүтээгдэхүүний орц, нормд орж буй бүтээгдэхүүний бүтэц, үйлдвэрлэлийн технологи, тоног төхөөрөмжийн шинэчлэлттэй уялдуулан стандартыг өөрчилж, шинэчлэх, хөгжүүлэлт хийх, судалгаа хийх шаардлага үүссэнийг илтгэж байна.

Дүрслэл 2. Сав, баглаа боодлын болон хүнсний технологийн стандартуудын баталсан он цагийн дараалал /тоогоор/



Салбарын яам судалгаа хийж, саналаа СХЗГ-т хүргүүлэн, таван жилийн үечлэлтэйгээр үзлэг хяналт хийж, өөрчлөлт шинэчлэлтийг баталдаг байна.

2021 оны байдлаар явуулын хоолны үйлчилгээ, хэрчсэн гурил, зарим төрлийн хүнсний нарийн ногоо, жимс, хоолны амтлагч зэрэг бүтээгдэхүүний стандартууд болон зарим үйлдвэрлэлийн техникийн зохицуулалтгүй, бүтээгдэхүүний шим тэжээлийг бүрэн шинжлэх стандарт байхгүй байна. Тухайлбал сүүнд 3 төрлийн бактери, тослог, хуурай бодисын үлдэгдэл, хүчиллэг тодорхойлох стандарттай бөгөөд бусад төрлийн шинжилгээний стандарт байхгүй байна.

СХЗГ-ын 2019 онд баталсан "MNS ISO 22000:2019 стандарт "Хүнсний аюулгүй байдлын менежментийн тогтолцоо. Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчид тавих шаардлага"-ыг "Үндэсний чанарын хөтөлбөр"-ийн 5.1.8-д "мах, махан бүтээгдэхүүн, чацаргана, зөгийн бал, хүнсний бүтээгдэхүүн, ноос, ноолуур, арьс шир, оёмол бүтээгдэхүүн, аялал жуулчлалын үйлчилгээ, хог хаягдлын стандарт олон улсын жишигт хүрсэн байна" гэж заасны дагуу 47 үйлдвэрээс мах боловсруулах 5 үйлдвэр тус стандартыг хэрэгжүүлэх итгэмжлэл авч хэрэгжүүлэн ажиллаж байна.


А.1.1.3 Хүнсний аюулгүй байдлыг сайжруулахад чиглэсэн үндэсний хөтөлбөрийн зорилт бүрэн хангагдаагүй байхад бүрэн хэрэгжсэнээр дүгнэсэн байна.

Орхон аймагт хэрэгжиж буй хүнсний аюулгүй байдлыг хангахад чиглэсэн үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтийг 95-100, аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ хянаж ЗГХЭГ-т хүргүүлэх хэрэгжилтийг 90-100 хувиар тус тус дүгнэсэн байна.

Аудитаар хөтөлбөрүүдийн зорилго, зорилтын арга хэмжээг тулгахад 1 хөтөлбөрийг үнэлэх боломжгүй, бусад хөтөлбөрүүдийн хэрэгжилт дунджаар 65.6 хувийн гүйцэтгэлтэй байлаа. Хөтөлбөрүүдийн зорилт, арга хэмжээ бүрд үнэлэх шалгуур үзүүлэлтгүйгээс хэрэгжилтийг үнэн зөв дүгнээгүй, хөтөлбөрүүдийн агуулга давхардсанаас шалтгаалан нэг арга хэмжээг 2-3 хөтөлбөрт тайлагнасан, аймгийн суурь түвшнээс өсөлтийг тооцоогүй, биелэлтийг товч, тодорхой тайлагнаагүй,

нуршсан, ач холбогдолгүй мэдээллийг тусгасан, холбогдох албан тушаалтнууд бүрэн хянаагүйгээс биелэлтийг бүрэн хэрэгжсэнээр үнэлсэн байна.

Дүрслэл 3. Үндэсний хөтөлбөр, аймгийн дэд хөтөлбөрийн биелэлт /%-аар/



Иймд дээрх байдалд дүн шинжилгээ хийж, албан тушаалтны ажлын хариуцлага, ур чадварыг дээшлүүлж, дотоод хяналтыг сайжруулах шаардлагатай байна.

А.1.1.4 Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилт хангалтгүй, хэрэгжихгүй байгаа нь хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдлыг бүрдүүлэхээр болсон байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангахтай холбоотой хуулийн зарим зүйл заалтын хэрэгжилт хангалтгүй, хэрэгжихгүй байгаа нь хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдлыг бүрдүүлэхээр болсон байна. Үүнд:

- Хүнсний тухай хуулийн 10.1.2-т “стандарт, техникийн зохицуулалтад нийцсэн барилга байгууламж, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл, агуулах, тээврийн хэрэгсэлтэй байх”, 10.1.6-д “үйл ажиллагаа эхлэхийн өмнө хуульд заасны дагуу байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийлгэсэн байх” гэж хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчдэд тавих шаардлагад заасан боловч өрхийн хүнс үйлдвэрлэгч нарт мөрдөгддөггүй, ариун цэвэр, эрүүл ахуйн нөхцөл хангахгүй байх эрсдэл үүсгэхээр байна.

- Хүнсний тухай хуулийн 11.1-д “Хүнсийг зөвхөн Монгол Улсад бүртгэлтэй хуулийн этгээд экспортолж, импортолно” гэж заасан боловч иргэн хүнсийг зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл нэрээр оруулж ирж ашиглах, Алтанбулаг, Замын-Үүдийн хилийн боомтоор иргэдэд үйлчилдэг суудлын автомашинаар хилээр оруулж буй хүнсний импортлох үйл явц нь зөрчилдөж, хүнсний аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх нөхцөл байдлыг үүсгэхээр байна.

- Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 6.5-д “Хяналтын байгууллага дор дурдсан үйлдвэрлэлийг шинээр эрхлэх хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгчийн энэ хуулийн 6.1-д заасан мэдээллийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор Хүнсний тухай хууль болон энэ хуульд заасан шаардлагыг хангаж байгаа эсэхэд урьдчилсан хяналт шалгалт хийж, дүгнэлт гаргана” гэж заасны дагуу зөвхөн мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, өндөг, сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, нялх, балчир, бага насны болон цэцэрлэгийн хүүхэд, ерөнхий боловсролын сургуулийн бага ангийн сурагчдад зориулсан хүнсний

түүхий эд, бүтээгдэхүүн болон хоол үйлдвэрлэлийг тусгайлан заасан нь бусад төрлийн хүнсний үйл ажиллагаа эрхлэгч эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадал, үндэсний стандарт мөрдөхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

- Мөн хуулийн 6.4-д “Хяналтын байгууллага энэ хуулийн 6.1-д заасан мэдээлэлд тулгуурлан эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг төлөвлөнө”, 6.6-д “Хяналтын байгууллага энэ хуулийн 6.5-д заасан хугацаанд дүгнэлт гаргаагүй тохиолдолд хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч үйлдвэрлэлээ эхлүүлэх эрхтэй” гэж заасан нь хяналтгүй, стандартад нийцэхгүй үйл ажиллагаа эрхлэгч олшрох, бага эрсдэлийн нөлөөгөөр хүнсний болон эрүүл ахуйн чанар алдагдах нөхцөл байдал бүрдүүлэхээр заалт байна.

А.2 Хүнсний аюулгүй байдлын бодлого, арга хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянах байгууллагуудын бүтэц, чиг үүргийг тодорхой болгож, ажлын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.

А.1.2.1 Төрийн болон төрийн бус байгууллагуудын хамтын ажиллагаа, уялдаа холбоо хангалтгүй байна.

Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд хүнсний түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах болон тус үйл ажиллагаанд хяналт тавих төрийн байгууллагын, Хүнсний тухай хуульд хүнсний аюулгүй байдлыг хангахад төрийн бус байгууллагын оролцоог тус тус хуульчилсан байдаг.

Орон нутгийн түвшинд төрийн байгууллагаас аймгийн ХХААГ, МХГ, МЭГ, төрийн бус байгууллагаас Монголын хүнсчдийн холбооны Орхон аймаг дахь салбар, Орхон, Булганы ХАҮТ, Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг ТББ-тай хамтран ажилладаг байна. Эдгээр ТББ-уудын хамтын ажиллагаа нь орон нутгийн үйлдвэрлэл эрхлэгчдийн үзэсгэлэн худалдаа, сургалт сурталчилгааг жилдээ 1-2 удаа хамтран зохион байгуулсан байна. Эдгээрээс дүгнэвэл хүнсний аюулгүй байдлыг хангах чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодыг нэгдсэн бодлогоор зохицуулдаггүй, тус тусын хууль, эрх зүйд нийцүүлж ажилладаг бөгөөд хоорондын уялдаа холбоо хангалтгүй байна.

“Хүнсний аюулгүй байдлыг хангах салбар дундын стратеги /2016-2021/ гэсэн бодлогын баримт бичиг байгаа боловч хэрэгжилтийг зөвхөн ҮАБЗ, ХХААЯ, БШУЯ, БОАЖЯ, Шадар сайдын ажлын алба, МХЕГ, СХЗГ ханган ажиллахаар тусгасан байна.

А.1.2.2 Хүнсний аюулгүй байдлын хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэгтэй 2 төрийн байгууллагын улсын байцаагчийн чиг үүрэг давхацсан байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах бодлогын чиг үүргийг аймгийн хэмжээнд аймаг, сумын ЗДТГ, ХХААГ, ЭМГ, түүнд хяналт тавих чиг үүргийг МХГ, МЭГ хэрэгжүүлдэг бөгөөд эдгээр байгууллагуудын чиг үүргийг Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17, 18 дугаар зүйлд тодорхойлж, холбогдох хууль, дүрэм, журмын хүрээнд ажиллаж байна.

Аймгийн ЭМГ-ын хүнсний аюулгүй байдлыг хангах талаарх үүргийг Хүнсний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 17.2.4-т “хоол хүнснээс шалтгаалсан байнгын болон өвчлөлийн үеийн тандалд судалгаа хийж, яаралтай авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, үр дүнг олон нийтэд мэдээлэх” гэж заасан бөгөөд тухайн чиг үүргийг хэрхэн хэрэгжүүлсэн талаарх иж бүрэн тайлан, мэдээг ирүүлээгүй болно. Энэ нь албан хаагч өөрчлөгдсөн, коронавируст халдварын өвчлөл, ажлын хариуцлага зэргээс шалтгаалж байна.

МЭГ-ын улсын ахлах байцаагч, улсын байцаагчийн болон МХГ-ын мал, амьтан, хорио цээр чанарын болон мал эмнэлгийн хяналтын улсын байцаагчийн нарын гүйцэтгэх чиг үүргийг албан тушаалын тодорхойлолтуудтай тулгахад давхацсан байна.

Иймд холбогдох хяналтын байгууллагуудын чиг үүргийг тухайн хууль, журамд тодорхой тусгаж, давхцалыг арилгах шаардлагатай байна.

А.1.2.3 Хүний эрүүл мэндэд учруулсан зөрчил, түүний нөхцөл, шалтгааныг судалсан сан үүсээгүй, халдварт өвчлөл мэдэгдэхүйц буурахгүй байсаар байна.

2016-2020 онд аймгийн хэмжээнд хүнсээр дамжин хүний эрүүл мэндэд учруулсан зөрчлийг аймгийн Цагдаагийн газар, ЭМГ-ын мэдээлэл, аймгийн статистикийн дүнтэй тулгасан болно. Үүнд:

- Хүнсээр дамжин хүний эрүүл мэндэд учруулсан эрүүл мэндийн халдашгүй байдлын эсрэг гэмт хэрэгт бүртгэгдээгүй байна.
- Хүнсээр дамжин халдварт өвчин буюу хоолны хордлогоор өвчлөгсдийн тохиолдол бүртгэгдсээр байгаа ба тоон үзүүлэлт дараах байдалтай байна.

Дүрслэл 4. Хүнсээр дамжин хүний эрүүл мэндэд учирсан хохирол буюу хоолны хордлогын үзүүлэлт тоо, хувиар



Хүнсээр дамжуулан хүний эрүүл мэндэд учруулсан зөрчлийг Эрүүл мэндийн сайдын 2017 оны А/328 дугаар тушаалаар баталсан “Хоол хүнсээр дамжих өвчний үеийн хариу арга хэмжээ авах журам”, “Хоол хүнсээр дамжих өвчний голомтод ажиллах заавар”, “Сорьц, шинжлэгдэхүүн цуглуулах ба түүнтэй харьцах заавар”-ын дагуу бүртгэж, Зөрчлийн тухай хуулийн дагуу шийдвэрлэжээ.

Хүнсээр дамжуулан хүний эрүүл мэндэд учирсан зөрчил, суурь шалтгаан, үр дагаврыг арилгах талаар хийсэн ажлын талаарх тайлан, мэдээллийг ЭМГ-аас ирүүлээгүй болно.

МХГ-ын хими, нян судлалын лабораторид нянгийн хордлогыг шинжилгээгээр тогтоож байгаа бөгөөд химийн хордлогыг тодорхойлдоггүй байна.

Улсын хэмжээнд үндэсний бодлогуудад мал, ургамлын гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний цахим нэгдсэн санг бий болгох, нэгдсэн бүртгэлээр хянадаг болохоор тусгасан ч бүрэн хэрэгжээгүйгээс хүний эрүүл мэндэд учруулсан зөрчил, түүний нөхцөл, шалтгааныг судалсан сан үүсээгүй, халдварт өвчлөл мэдэгдэхүйц буурахгүй байсаар байна.

Иймд мал эмнэлгийн нэгдсэн системийг цогцоор хөтөлж сайжруулан, ургамлын гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний цахим сан бий болгож, шилэн хяналтын систем /www.hyanalt.gov.mn/, статистикийн мэдээллийн нэгдсэн сан /www.1212.mn/-тай уялдуулах шаардлагатай байна.

А.1.2.4 Аймгийн гамшгаас хамгаалах, бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг баталж, салбар дундын зохицуулалт нэгдсэн удирдлагаар хангагдсан байна.

Шадар сайд, газар хөдлөлтийн гамшгаас урьдчилан сэргийлэх байнгын ажиллагаатай зөвлөлийн даргын 2017 оны 08 дугаар тушаалаар баталсан “Болзошгүй гамшиг, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлын үеийн салбар хоорондын мэдээлэл солилцох, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах журам”-аар хүнсний аюулгүй байдал алдагдах, нийтийг хамарсан хордлого, халдварын тохиолдол, онцгой нөхцөл байдал, хямрал үүсэх эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх, үүссэн үед хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах, салбар дундын зохицуулалтыг журамласан байна.

Аймгийн Засаг дарга гамшгаас хамгаалах арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, удирдах, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдаж, аймгийн ИТХ гамшгийн эрсдэлийг бууруулах хөтөлбөр болон гамшгаас хамгаалах төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгөд жил бүр 100.0 -150.0 сая төгрөгийг баталсан байна.

Харин ОБГ нь гамшгаас хамгаалах албаны гүйцэтгэх үүргийг тодорхойлж, мэргэжлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлж, салбар хоорондын байгууллагуудтай хамтран эрсдэлийн үнэлгээ хийж, хариу арга хэмжээ авах, бэлэн байдлыг хангах үүргийг хэрэгжүүлсэн байна.

Гамшгийн үеийн аймгийн хүн амд шаардагдах 100 хоногийн хүнсний бүтээгдэхүүний хэрэгцээг тооцож, 2019 оны 11 сараас хойш судалгааг гаргасан байна.

А.3 Хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан чанарын стандартыг мөрдсөн, олон улсын жишигт нийцсэн эрүүл, шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой хангахад анхаарахаар болсон байна.

А.1.3.1 Аймгийн гол нэрийн хүнсний нөөцийн тооцооллыг жишсэн хүн амаар тооцсон ба хаврын улиралд махны нөөцийн асуудлыг шийдвэрлэхэд орон нутгийн төсвөөс дэмжлэг үзүүлжээ.

Аймгийн хэмжээнд тухайн хүнсний бүтээгдэхүүний жилийн нийт нөөцийг жишсэн хүн амын хүнсний жилийн хэрэгцээнд харьцуулснаар тодорхойлж байгаа бөгөөд жилийн эцсийн суурин хүн амын тоо 2019 онд 104,032, жишсэн хүн амын тоо 82,381 байна. 2020 онд суурин хүн амын тоо 105,361, жишсэн хүн амын тоо 84,110 болжээ.

Манай аймгийн хүн амын хүнсний гол нэрийн 16 бүтээгдэхүүний зохистой хэрэгцээг 2020 оны байдлаар тооцож үзвэл, жилд нийтдээ 3.7 мянган тонн мах, махан бүтээгдэхүүн, 4.9 мянган тонн сүү, сүүн бүтээгдэхүүн, 3.0 мянган тонн гурил, 5.5 мянган тонн гурилан бүтээгдэхүүн, 1.5 тонн будаа, 1.0 мянган тонн сахар, чихрийн зүйл, 3.6 мянган тонн төмс, 7.9 мянган тонн хүнсний ногоо, 1.2 мянган тонн буурцагт ургамал, 6.1 мянган тонн жимс, жимсгэнэ, 0.6 мянган тонн өндөг, 0.7 мянган тонн ургамлын тос, 0.3 мянган тонн цөцгийн тосны хэрэгцээтэй байна. Жишсэн хүн амын жилийн хүнсний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлийн мах, махан

бүтээгдэхүүнээр 85.6 хувь, төмсөөр 100.0 хувь, хүнсний ногоогоор 53.0 хувийг хангаж байна.

2019, 2020 онуудад аймгийн хүн амын махны хэрэгцээнд 300 тонн үхэр, хонь, ямааны мах бэлтгэхэд аймгийн ЗДТГ-аас Эрдмийт ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж, хөнгөлөлт олгон, 3 дугаар сарын 15-ны өдрөөс 6 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл хугацаанд ангилан савласан үхэр, хонь, ямааны махыг зах зээлийн үнээс 1000-1500 төгрөгөөр хямд борлуулах ажлыг зохион байгуулсан байна. Эрүүл ахуйн шаардлага хангасан, хямд үнэтэй махаар хаврын турш иргэдийг хангасан байна.

ОБЕГ-ын Улсын нөөцийн салбар манай аймагт ОБГ-ын харьяанд ажилладаг бөгөөд улсын стратегийн нөөцөд хамаардаг тул байршил, тоо хэмжээний мэдээлэл нууцад хамааралтай учраас аудитад хамруулаагүй болно.

А.1.3.2 Хүнсний шим тэжээл, чанар, аюулгүй байдлыг шинжилж байгаа лабораторийн үйл ажиллагаа зохих түвшинд тогтмол ажиллаж байгаа ч барилга байгууламж, тоног төхөөрөмжийг стандартад нийцүүлж, хүчин чадлыг сайжруулахаар болсон байна.

Аймгийн хэмжээнд МХГ-ын хими, нян судлалын лаборатори, МЭГ-ын мал эмнэлгийн лаборатори, Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын химийн лаборатори ажиллаж байгаа бөгөөд Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ-ын химийн лабораторийг аудитад хамруулаагүй болно.

Хүснэгт 1. Аймгийн лабораториудын хүчин чадал, хангамжийн судалгаа

Үзүүлэлт	МХГ-ын хими, нян судлалын лаборатори	МЭГ-ын мал эмнэлгийн лаборатори
Хүчин чадал, түүний ашиглалт	9 төрлөөр 58 нэр төрлийн бүтээгдэхүүнд 508 үзүүлэлтээр хими, хор судлал, нян судлалын шинжилгээ	5 төрлөөр 9 нэр төрлийн бүтээгдэхүүнд 130 үзүүлэлтээр ариун цэвэр, нян судлал, эмийн үлдэгдлийн шинжилгээ
Итгэмжлэл	4 жилийн хугацаатай, 2024.02.18 хүртэл	2020 оны 11 сард итгэмжлэлийн хугацааг сунгуулахаар хандсан.
Тоног төхөөрөмж	67 нэр төрлийн тоног төхөөрөмж, хэмжих хэрэгсэл, 156 нэрийн химийн бодис урвалж оношлуур, 1344 шил сав, туслах хэрэгсэл, 260 стандарт	77 нэр төрлийн тоног төхөөрөмж, хэмжих хэрэгсэл, 104 нэрийн химийн бодис урвалж оношлуур, 980 шил сав, туслах хэрэгсэл, 62 стандарт
Хүний нөөц	6	4
Ажлын байр	Нийтийн орон сууцанд үйл ажиллагаа явуулдаг.	Нийтийн орон сууцны зориулалттай, төрийн байгууллагын байранд үйл ажиллагаа явуулдаг.
Тулгамдаж буй асуудал	Хүнсний бүтээгдэхүүн, орчин, бусад шинжилгээний аюулгүйн үзүүлэлтийн шинжилгээний 50 хувийг хийдэг. Хүнд металл тодорхойлох багажгүй. Хор судлалын оношлуур өндөр үнэтэй. 2012 оноос хойш тоног төхөөрөмжийн шинэчлэл хийгээгүй.	Зориулалтын бус ажлын байранд үйл ажиллагаа эрхэлдэг. Шинжилгээний урвалж бодис, оношлуур өндөр үнэтэй. 2020 оны 11 сард итгэмжлэлийн хугацааг сунгуулахаар хандсан боловч шалгуурыг хангуулахад ажлын байрны нөхцөлөөс шалтгаалан олгогдоогүй байгаа.

Хүснэгт 2. Аймгийн лабораториудын шинжилгээ, үзүүлэлтийн судалгаа /тоогоор/

№	Байгууллага	Үзүүлэлт /оноор	2018 он	2019 он	2020 он	2021 он
1	Аймгийн МХГ-ын лаборатори	Сорьцын тоо	1,922	2,274	2,098	1,245
		Дотоодын бүтээгдэхүүн	1,580	1,883	1,589	1,032
		Импортын бүтээгдэхүүн	342	391	509	213
		Үзүүлэлтийн тоо	4,110	4,473	3,812	2,311
		Шаардлага хангаагүй сорьцын тоо	85	109	119	81
		Шаардлага хангаагүй сорьцын хувь	4.4	4.8	5.7	6.5
2	Аймгийн МЭГ-ын лаборатори	Сорьцын тоо	759	915	759	478
		Үзүүлэлтийн тоо	119	108	106	106
		Шаардлага хангаагүй сорьцын тоо	33	18	15	13
		Шаардлага хангаагүй сорьцын хувь	4.3	2.0	2.0	2.7

Аймгийн хэмжээнд үр, хорио цээрийн шинжилгээ хийдэггүйгээс Булган, Дархан-Уул аймгийн МХГ-ын лабораториудад шинжлүүлдэг бол хүнсний бүтээгдэхүүний шимт чанарын шинжилгээ огт хийдэггүй байна.

МХГ-ын болон МЭГ-ын лабораториуд нь MNS 6815 : 2019 “Лабораторийн био аюулгүйн зэрэглэл, Ерөнхий шаардлага”, MNS ISO/IEC17025:2018 “Сорилтын болон шалгалт тохируулгын лабораторийн чадавхад тавих ерөнхий шаардлага” стандартад заасан лабораторийн ажлын байранд тавигдах шаардлага болох гадаад орчноос бүрэн тусгаарлагдан байрласан байх, тусгай зөвшөөрөлтэй нэвтэрдэг, харуул хамгаалалт бүхий дохиолол, хяналтын камертай байхаар заасан шаардлагыг хангахгүй байна. Энэхүү асуудлыг улсын хэмжээнд нэгдсэн бодлогын хүрээнд шийдвэрлэх шаардлагатай гэж үзлээ.

А.1.3.3 Аймгийн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл хэрэгцээгээ бүрэн хангаж чадахгүй байгаад анхаарахаар болжээ.

Орхон аймагт хүнсний үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэн 85 бүртгэлтэйгээс 2020 онд 39 буюу 45.9 хувь нь үйл ажиллагаа явуулжээ. Бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбараар авч үзвэл сүү, сүүн бүтээгдэхүүн, үр тарианы үйлдвэрлэл хангалтгүй, бүрэн хүчин чадлын 10 хүртэл хувийг ашигласан байна.

Хүснэгт 3. Аймгийн хүнсний үйлдвэрлэлийн тоо, хүчин чадал ашиглалт /тоогоор, хувиар/

д/д	Бүтээгдэхүүн	хэмжих нэгж	Үйлдвэрлэл эрхлэгч аж ахуйн нэгж, иргэний тоо		Хүчин чадал, ашиглалт		
			бүртгэлтэй	2020 онд үйл ажиллагаа явуулсан	хүчин чадал	2020 оны үйлдвэрлэлт	Ашиглалт /хувь/
1	мах, загас, жимс, ногоо, өөх, тос боловсруулалт	тонн	9	7	8,400.0	1,470.0	17.50
2	сүү, сүүн бүтээгдэхүүн үйлдвэрлэл	мян.литр	6	3	7,100.0	738.4	10.40
3	үр тарианы гурил, цардуул, малын тэжээл	тонн	5	3	43,252.0	201.6	0.47
4	гурилан бүтээгдэхүүн үйлдвэрлэл	тонн	58	20	2,526.5	1,239.2	49.05
5	архи, пиво, ус, ундааны үйлдвэрлэл	мян.литр	7	6	8,106.3	2,740.1	33.80
	Дүн		85	39			

Аймгийн статистикийн дүн мэдээлэлд тулгуурлан жишсэн хүн амын жилийн хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний хэрэгцээг дотоодын үйлдвэрлэлтэй харьцуулахад төмсний хэрэгцээ бүрэн хангаж байх ба мах, сүү, гурил, хүнсний ногооны 4-51 хувийг хангаж байна.

ХХААГ нь салбарын хэмжээнд мах, сүүний нөөцийг тооцохдоо малын тоо, нядалгааны жин, сүүний гарц, саалийн хоног зэрэг үзүүлэлтийг харгалзан, нэгж бүтээгдэхүүнд шилжүүлэн тооцох коэффициентийг ашиглажээ. Нэгж бүтээгдэхүүнд шилжүүлсэн тооцооллоор мах, сүүний дотоод үйлдвэрлэл 77-89 хувьтай байна.

Энэхүү тооцооллыг авч үзвэл тухайн орон нутгийн хүнсэнд хэрэглэсэн малын тоо, саальд хамрагдах үнээний тооноос хамааралтай байх ба бусад аймаг руу борлуулсан болон бусад орон нутгаас нийлүүлсэн мах, сүүний хувь, хэмжээг тооцох боломжгүй байна. Улсын хэмжээний малын тооллоготой уялдуулан тооцсон тооцоолол нь бодитой боловч орон нутгийн хэмжээнд бодитой бус байна.

Төрөл бүрийн будаа, сахар, чихрийн зүйл, загас, шувууны мах, буурцагт ургамал, жимс, өндөг зэргийг импортын хүнсний бүтээгдэхүүнээр хангаж байна.

Орхон аймгийн гүний гаалийн хяналтын талбайгаар Сэлэнгэ аймгийн Алтанбулаг боомтоор импортоор 3.0 мянган тонн ургамал, ургамлын гаралтай бүтээгдэхүүн импортолж, 575.0 тонн малын хөлдүү мах экспортолсон байна.

Орон нутагт хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжиж, хэрэгцээ хангах бодлогыг үйл ажиллагаа зорилго, зорилтдоо тусган хэрэгжүүлэх шаардлагатай байна.

А.1.3.4 Хүнсний сүлжээнд хэрэгжиж буй чанарын удирдлага, хяналт үр нөлөөгүй байна.

Хүнсний аюулгүй байдалд хяналт тавих үйл ажиллагааг зах зээл дэх хүнсний чанар, шим тэжээллэг байдалд хийх тандалт судалгаа, төрийн хяналт, гаалийн болон хорио цээрийн хяналт, хуульд заасан хүрээ, хязгаарын дотор мэргэжлийн холбоо, ТББ, иргэн байхаар хуульчилсан. Эдгээрийн хэрэгжилтийг аймгийн хэмжээнд авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

- Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч хүнсний сүлжээний өөрт хамаарах үе шат бүрийн дотоод хяналт муу байна. Энэ нь аймгийн МХГ-т бүртгэлтэй хүнсний үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагааг тулган баталгаажуулахад зохистой дадлыг бүрэн мөрдөөгүй, байршил өөрчлөгдсөнийг хяналтын байгууллагад мэдэгдээгүй, зураасан кодыг бүрэн ашиглаагүй, ажилтныг эрүүл мэндийн үзлэгт журмын дагуу бүрэн хамруулаагүй, ариун цэврийн шаардлага бүрэн хангахгүй байгаа нь хүнсний чанарын болон түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдлын удирдлага хангалтгүй хэрэгждэгийг илтгэж байна.
- “Орхон аймгийн нутаг дэвсгэрт согтууруулах ундаа худалдах, түүгээр үйлчлэх тусгай зөвшөөрөл олгох, хяналт тавих журам”-ын 3.1.1-д үйл ажиллагааны төрлөөс хамаарч стандартын шаардлага хангаж, тохирлын гэрчилгээ авсан байх заасан хэдий ч 2020-2021 оны тусгай зөвшөөрөл олгох, сунгасан аж ахуйн нэгжүүдийн тухайн шаардлага хангасан эсэхийг тулгаагүй, нотлох баримтыг шаардаж аваагүй байна.
- Аймгийн МХГ-ын хяналт шалгалт эрсдэлд суурилдаг бөгөөд сүүлийн 5 жилийн хяналт шалгалтын мэдээнээс үзвэл нийт хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны эрхлэгчдийн 40 гаруй хувьд хяналт шалгалт хийдэг байна. Үүнийг салбараар авч үзвэл хүнсний үйлдвэрлэлийн чанар, стандартын хяналтыг 38.7%-д, хүнсний худалдааны чанар, стандартын хяналтыг 7.5%-д, хоол үйлдвэрлэлийн хүнсний чанар стандартын хяналтыг 20.2%-д, мал эмнэлгийн хяналт /МАА гаралтай хүнсний үйлдвэр/-ыг 63.8%-д, таримал ургамлын үр, хорио цээрийн хяналтыг 41.3%-д тус тус хийжээ. Аудитаар бага эрсдэлтэй 30 хүнсний үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагааг тулган баталгаажуулахад үйл ажиллагаа хэвийн явагдаагүй, байршлаа өөрчилсөн, ажлын байр стандартын шаардлага хангаагүй, зохистой дадлыг бүрэн мөрдөөгүй зэрэг зөрчил илэрсэн. Энэ нь тухайн эрсдэлд суурилсан хяналт үр нөлөөгүйг илтгэж байна.

- Гаалийн болон хилийн хорио цээрийн хяналт хангалтгүй нь хүнсний сав, баглаа боодол, иргэн хүнсийг зорчигчийн хувийн хэрэглээний эд зүйл нэрээр оруулж ирж худалдан борлуулж байгаагаар илэрч байгаа бөгөөд манай аймгийн гаалийн хяналтаар энэ асуудлыг нотлох боломжгүй байна.
- Мэргэжлийн холбоо болон ТББ-ын хяналт манай аймагт хэрэгждэггүй, зөвхөн үзэсгэлэн худалдаа зохион байгуулдаг байна.

Аймгийн хүнс, хоол, худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд нэгдсэн хяналт шалгалт хийж, илэрсэн алдаа зөрчлийг арилгуулах, түүнд шинжилгээ хийж, байгууллагуудын ажлын уялдааг хангуулах шаардлагатай байна.

А.1.3.5 Хүнсний сүлжээний бүх үе шатны нэгдсэн бүртгэл, хяналт, мэдээллийн тогтолцоо бүрдээгүй байна.

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 4.1.6-д “хүнсний сүлжээний бүх үе шатанд бүртгэл, чанарын удирдлага, хяналт, баталгаажуулалтын тогтолцоог төлөвшүүлж хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах ажлыг эрчимжүүлэх”, 4.1.17-д “мал аж ахуй, газар тариалан, хүнсний үйлдвэрлэл, экспорт, импорт, хүн амын хүнсний хэрэглээний нэгдсэн мэдээллийн сан, сүлжээ бий болгох, хүнсний аюулгүй байдлын статистикийн үзүүлэлттэй холбох” гэж тусгасан ч хэрэгжээгүй байна. Тухайлбал:

- Газар тариалангийн “Ургамлын гарал үүсэл, пестицидийн бүртгэл, хяналтын систем”-д 8 аж ахуй нэгж, 100 гаруй өрхийн тариаланчдын 361 нэгж талбарыг /гэрчилгээний дугаараар/ бүртгэсэн ч ашиглаагүй байна.
- Малын эмнэлгийн нэгдсэн систем, тандалт судалгаа, лаборатори, махны үйлдвэрийн үйл ажиллагааг хянах систем үүсгэсэн боловч бүрэн ашигладаггүй байна.
- Хүнсний бүтээгдэхүүний бүртгэлийн сан үүсгээгүй байна.

А.1.3.6 Аймагт шим тэжээллэг болон органик хүнс үйлдвэрлэж эхлээгүй байна.

Органик хүнсний тухай хуулийг нийтэд сурталчлан таниулах зорилгоор 2019 онд “Алсыг харъя-Органикийг сонгоё” сарын аяныг зохион байгуулсан бөгөөд одоогийн байдлаар манай аймагт органик хүнсээр баталгаажуулсан бүтээгдэхүүн үйлдвэрлээгүй, бүртгээгүй байна.

А.1.3.7 Хүний эрүүл мэндэд хор хөнөөлгүй, эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, байгаль орчинд ээлтэй, зориулалтын хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгыг хүнсний сүлжээний бүх шатанд хэрэглэж хэвшээгүй, түүнд тавих хяналт үр нөлөөгүй байна.

Хүнсний сав, баглаа боодол, хаяг шошгод хяналт хэрэгжүүлэх талаар Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 18.1.2-т “хүнсний сүлжээнд ашиглах болон хэрэглэх эд зүйлс, барилга байгууламж, ажлын байр нь эрүүл ахуйн болон ариун цэврийн шаардлага хангаж байгаа эсэхэд үзлэг шалгалт хийх” гэж заасан нь МХГ-ын чиг үүрэг байна.

Аймгийн МХГ нь 2017 онд хуванцар савны тандалт судалгаа хийсэн ба хүнсний, хоолны үйлдвэрлэлийн болон худалдаа эрхлэгч нийт 152 аж ахуйн нэгж, иргэний бүтээгдэхүүний сав, баглаа боодол, нэг удаагийн хоолны сав, халбага, сэрээ, соруул, аяга, усны сав, таваг зэрэг 6 нэр төрлийн 37 дээжийг шинжилгээнд хамруулахад нян судлалын лабораторид 3, хими судлалын лабораторид 16 эерэг

үзүүлэлттэй гарчээ. Тандалт судалгааны явцад нийт 64 зөрчил илрүүлж, 56 зөрчлийг арилгуулсан байна.

2018 онд “Хүнсний сав баглаа боодол” техникийн ерөнхий шаардлага MNS 5547:2005, “Сав, баглаа боодлын материалд агуулагдах хүнсний бүтээгдэхүүнд шилжиж болзошгүй химийн бодисын зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS5684:2006 стандартын үзүүлэлтийг тогтоох урьдчилан сэргийлэх хяналт шалгалтыг хоол, хүнсний үйлдвэрлэлийн болон худалдаа үйлчилгээний нийт 127 аж ахуйн нэгж, иргэний ашиглаж байгаа болон худалдан борлуулж байгаа зориулалтын тэмдэг, тэмдэглэгээгүй, чанар, аюулгүй байдлын баталгаажилтгүй, гарал үүсэл тодорхойгүй 10 нэр төрлийн хуванцар савнаас нийт 37 дээж авчээ. 12 дээжийг Хүнсний аюулгүй байдлын үндэсний лавлагаа лабораторид хүнд металлын шинжилгээнд, 30 дээжийг аймгийн МХГ-ын лабораторид 3 үзүүлэлтээр химийн шинжилгээнд хамруулахад шинжилгээний дүнгээр, БНХАУ-д үйлдвэрлэсэн шанага, хүүхдийн усны аяга, хоолны хар аяга, БНСУ-д үйлдвэрлэсэн шанаганд формальдегид нь стандарт хэмжээнээс их гарчээ.

2019-2020 онд хүнсний үйлдвэрлэл, үйлчилгээнд ашиглаж буй сав, баглаа боодлын чанар, аюулгүй байдлын өнөөгийн түвшин-хяналт сэдэвт сургалтад хүнс, хоолны үйлдвэрлэл эрхлэгчдийг хамруулсан бөгөөд хяналтын талаар тодорхой мэдээлэл ирүүлээгүй болно.

Аймгийн ХХААГ нь хүнсний зориулалтын хуванцар савны хор нөлөөллийн талаар сургалт, мэдээлэл, сурталчилгааг зохион байгуулж, цахим хуудас, орон нутгийн телевизээр сурталчилжээ.

Орхон аймагт сав, баглаа боодлын үйлдвэрлэл эрхлэгч байдаггүй бөгөөд сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг бодлогын хүрээнд дэмжих хэрэгтэй байна.

Аудитын явцад үйл ажиллагаанд хяналт хэрэгжүүлсэн хүнс үйлдвэрлэгч аж ахуйн нэгж, иргэний сав, баглаа боодол, хаяг, шошгыг шалгахад Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуулийн 12.4-т заасан мэдээллийг бүрэн агуулаагүй, стандарт шаардлага хангаагүй зэрэг зөрчлүүд илэрч байсан нь хяналт үр нөлөөгүй, хууль, эрх зүйн акт бүрэн хэрэгждэггүйг илтгэж байна.

А.1.3.8 Хүнсний аюулгүй байдлын талаар иргэдийн мэдлэг дээшлүүлэх арга хэмжээний хүрээнд хүн амын 14 хувийг хамруулсан хэдий ч үр дүнг бүрэн тооцох боломжгүй байна.

Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогын 4.1.18-д “хүн амын хоол, хүнсний талаарх мэдлэг, боловсролыг дээшлүүлэх, хоол, хүнсээ сонгох, хэрэглэх, хадгалах хандлагыг өөрчлөх, хяналт тавих дадал төлөвшүүлэх, өрхийн хүнсний хэрэгцээгээ хангах, сайжруулах оролцоог нэмэгдүүлэх” арга хэмжээг аймгийн ЗДТГ, ХХААГ нь 100 хувь биелсэн гэж дүгнэжээ. Дараах үр дүн гарснаар тайлагнажээ. Үүнд:

- Аймгийн Засаг даргын 2019 оны А/40 дүгээр захирамжаар “Давс багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэмжье” аян, “Давсны хэрэглээг бууруулах үндэсний стратеги”-ийн хүрээнд 32 аж ахуйн нэгж, иргэн, 117 төрлийн бүтээгдэхүүнийг хамруулсан бөгөөд бүтээгдэхүүний давсны агууламж дунджаар 50 хувиар буурсан.
- Нийт 104 удаагийн сургалт, 140 өдөрлөг, үзэсгэлэн арга хэмжээг зохион байгуулж, сургалтад 3,158 хүн, өдөрлөг арга хэмжээнд 10,804 хүнийг хамруулж, хэрэглэгчээс сэтгэл ханамжийн асуумж судалгааг 7,067 хүнээс авч, сургалтын гарын авлага материал 16,591 ширхгийг олшруулан тарааж, орон нутгийн 6 хэвлэл мэдээллийн байгууллага, 1 сайттай хамтран эрүүл мэндийн нөлөөллийн ажлыг нийт 16 удаа хийж, богино хэмжээний видео шторкийг нийтлэн ажилласан.

ЭМГ-аас үндэсний хөтөлбөрүүдэд холбогдох тайлан, мэдээг авч нэгтгэдэггүй бөгөөд тус байгууллагаас ирүүлсэн тайланд Дэлхийн хүнсний аюулгүй байдлын өдрийг "Хүнсний аюулгүй байдлыг хангахад хүн бүрийн оролцоо" уриа дор 2020 оны 06 дугаар сарын 07 -ны өдөр, Монгол улсын Засгийн газрын 224 дүгээр тогтоолын дагуу "Гэдэсний халдварт өвчнөөс сэргийлэх үе" 6 дугаар сарын 2 долоо хоногт тэмдэглэн өнгөрүүлжээ.

- "Цусан суулга өвчний талаар та мэдэх үү?", "Гэдэсний халдварт өвчнөөс сэргийлцгээ", "Хоол бэлтгэлийн аюулгүй байдал", "Цусан суулга өвчний үед ямар шинж тэмдэг илрэх вэ?" зэрэг 4 төрлийн зурган мэдээлэл 110 ширхэг хэвлэн эмийн сангууд, хүнсний, худалдаа үйлчилгээний нийт 18 байгууллагад түгээсэн ба эрүүл мэндийн газрын цахим хуудсанд, "Хүнс бохирдохоос сэргийлье", "Хүнсний ногоо, жимсний аюулгүй байдлыг хангах", "Хүнсний аюулгүй байдлыг хангах 5 зарчим", "Мах, махан бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах" сэдэвтэй сургалтын материал байршуулж давхардсан тоогоор 2058 хүний хандалт авчээ.
- ӨЭМТ-үүд үйлчлүүлж буй 263 иргэнд "Суулгалт халдвараас сэргийлье" сэдвээр сургалт зохион байгуулсан ба "Гэдэсний халдварт өвчнөөс сэргийлье", "Суулгалт өвчний үед авах арга хэмжээ", "Цусан суулга өвчин, түүнээс урьдчилан сэргийлэх" зурагт хуудас, хүнсний болон ундны усны зөв хэрэглээний талаар зөвлөмж 1477 иргэнд түгээн ажилласан байна.
- Иргэдийн эрүүл мэндийн боловсрол дээшилж, гэдэсний халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулан, цусан суулга өвчний тохиолдол өмнөх оноос буурсан үр дүн гарсан гэж тайлагнажээ.

Эдгээр биелэлтүүдээс гарсан үр дүн, үр өгөөжийг тооцоолох боломжгүй, хүн амын 14 хувийг сургалт, өдөрлөгт хамруулж, оролцсон хүний тооноос илүү гарын авлага, материал тараасан байна. Аймгийн статистикийн дүн мэдээнээс үзвэл хүн амын гэдэсний болон зоонозын халдварт өвчлөл бага зэрэг буурч, дотоодын үйлдвэрлэл бага зэрэг нэмэгдсэн хэдий ч аймгийн хүн амд зөв дадал хэрхэн төлөвшиж, хоол хүнс сонгох хандлага хэрхэн өөрчлөгдсөн, иргэдийн оролцоо нэмэгдсэн зэргийг тодорхойлох боломжгүй байна.

Иймд хүнсний аюулгүй байдлын талаар хүн амын хүнсний талаарх мэдлэг олгох, сайжруулах, хоол, хүнсээ сонгох, зөв дадалд суралцах, хүнсний үйл ажиллагаанд хяналт тавих, үр дүнг үнэн зөв үнэлэх цогц арга хэмжээ хэрэгжүүлэх шаардлагатай байна.

БҮЛЭГ 2. Хүнсний аюулгүй байдлыг хангахад төсвөөс зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлээгүйгээс зориулалт бусаар зарцуулж, төвлөрүүлэх орлогыг төвлөрүүлээгүй байна.

Б.1 Төсвийг үр ашигтай төлөвлөсөн байна.

Б.2.1.1 Аймгийн дэд хөтөлбөрт суурилан төсвийг төлөвлөсөн байна.

Хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр хэрэгжүүлэх чиглэлээр Засгийн газраас үндэсний хөтөлбөрүүдийг дараах агуулгатайгаар баталсан байна.



Аймгийн ИТХ-аар хүнсний аюулгүй байдлыг хангах чиглэлээр “Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр”, “Өрхийн тариалалтыг дэмжих дэд хөтөлбөр”, “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх II үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлахдаа Засгийн газраас баталсан үндэсний хөтөлбөрүүдтэй нийцүүлсэн байна.

Тус дэд хөтөлбөрүүдэд төсөв төлөвлөхдөө Төсвийн тухай хууль, Орхон аймаг, Эрдэнэт хотын “Ногоон, тогтвортой хөгжлийн хэтийн зорилт 2025”, аймгийн Засаг даргын 2016-2020 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр болон аймгийн

нийгэм, эдийн засгийг хөгжүүлэх үндсэн чиглэлтэй нийцүүлж төлөвлөсөн байна.

Б.2.1.2 Зорилт, арга хэмжээнд хөрөнгө төлөвлөхдөө хэрэгцээ, шаардлага, үр ашгаар эрэмбэлсэн байна.

“Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлогыг хэрэгжүүлэх аймгийн дэд хөтөлбөр”, “Өрхийн тариалалтыг дэмжих дэд хөтөлбөр”, “Ус” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх II үе шатны үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу төсвийг төлөвлөхдөө төсвийн шууд захирагчдын хүсэлт, холбогдох дүгнэлт, тооцоо судалгаанд үндэслэсэн байна.

Орон нутгийн төсвийн төсөлд ирүүлсэн төсөл, хөтөлбөрийн жагсаалтыг аймгийн ЗДТГ-ын холбогдох хэлтэс, албад нэгтгэж, жагсаалт гарган, аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж, аймгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх саналыг боловсруулж, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн баталсан байна.

Б.2 Төсвийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлд хяналт хэрэгжээгүй байна.

Б.2.2.1 Төсвийн хөрөнгийг үргүй зарцуулж, аж ахуйн нэгж улсаас олгосон зээлийг зориулалтын бусаар зарцуулж, төсөв төвлөрүүлэх орлогыг төвлөрүүлээгүй байна.

Үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд олгож буй зээл, тусламжийг ХХААЯ-аас тухайн ААНБ-д олгодог байна.

2018 – 2020 онд үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд улсын төсвөөс 822.8 сая төгрөгийн үр, хүлэмж, вакцин, орон нутгийн төсвөөс үндэсний хөтөлбөрийн санхүүжилтэд 1,601.8 сая төгрөгийн өвс тэжээл, нөөцийн мах бэлтгэх, вакцины үйлчилгээний хөлс, сургалт, үзлэгийн хөлс, орон нутгийн 2 дэд хөтөлбөрийн санхүүжилтэд 463.5 сая төгрөгийн хүлэмж, үр зэрэгт хөрөнгө зарцуулжээ.

Аудитын цаг хугацаа хязгаарлагдмал байдлаас шалтгаалан эрсдэлтэй гэж үзсэн өвөлжилтийн бэлтгэл хангах өвс тэжээлийн 304.2 сая төгрөгийн зарцуулалт, сургалт сурталчилгаа, үзэсгэлэн худалдаа, малын үзлэгийн шалгалтын 57.1 сая төгрөгийн байгууллагын урсгал зардлыг хамруулаагүй болно.

Энэхүү төсвийн хөрөнгийн зарцуулалтыг ЖДҮХСангаас 2019-2020 онд олгосон зээлийн хэрэгжилт, Өрхийн тариалалтыг дэмжих дэд хөтөлбөрийн хэрэгжилт, Баян-Өндөр, Жаргалант сумдын сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн хэрэгжилтийг шалгасан бөгөөд дараах зөрчлүүд илэрлээ. Үүнд:

ЖДҮХСан

- 2019 - 2020 онд нийт 1,304.2 сая төгрөгийн зээл авсан 14 аж ахуйн нэгж, иргэний үйл ажиллагааг тулган баталгаажуулахад 2 аж ахуйн нэгж 130.0 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулаагүй, төслийг хэрэгжүүлээгүй байна.

Өрхийн тариаланг дэмжих дэд хөтөлбөр

- “Өрхийн тариалалтыг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд төмс, хүнсний ногоо үр, хүлэмж олгох журам”-ыг аймгийн Засаг даргын 2018 оны 05 сарын 23-ны өдрийн А/325 дугаар захирамжаар баталсан байна. Тус журмыг 2021 онд шинэчлэхдээ Засаг даргын захирамжаар баталгаажуулаагүй байна.

- Шинэчилсэн журамд хүлэмжийн үнийн 50 хувийг Жаргалант сумын ЗДТГ-ын нэмэлт санхүүжилтийн дансанд тушаахаар тусгасан нь тухайн хөтөлбөрт аймгаас зарцуулсан хөрөнгийг тухайн дансанд эргэн төвлөрүүлэхгүй, шууд худалдан авалт хийх нөхцөлийг бүрдүүлсэн байна. 2021 онд олгосон 12 хүлэмжийн 50 хувь болох 14.7 сая төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлэхгүй, холбогдох шийдвэргүйгээр зарцуулсан байна.

- Хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хяналт тавих байгууллагуудын чиг үүргийг тодорхой тусгаагүйгээс гадна аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ, СТСХ-ийн үүргийг тусгаагүй байна.

- Хүлэмжийг 100 хувийн хөнгөлөлтэй нөхцөлөөр аймгийн Засаг даргын захирамжаар олгохдоо хөнгөлөлт үзүүлэх тодорхой нөхцөл, шалтгааныг тусгаагүй, өөрийн өмчлөлийн болон эзэмшлийн газартай, төмс хүнсний ногоо тарих зориулалтын талбайтай эзэмших эрхтэй байх, тариаланчдын баталгааны тэмдэгтэй байх гэсэн шалгуурыг хангасан эсэхийг тодорхойлоогүй, 2018 оны А/325 дугаар захирамжаар баталсан журамтайгаа нийцэхгүй байна.

- Өрхийн тариалалтыг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд аймгийн ХХААГ нь 2020 - 2021 онд нийт 47.8 сая төгрөгийн 19 хүлэмжийг үнэ төлбөргүй, шийдвэргүйгээр, анхан шатны баримтын бүрдлийг бүрэн хангуулахгүйгээр олгосон байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16.5.2-д “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих” гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд 14.7 сая төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 47.8 сая төгрөгийн албан шаардлага, нэгдсэн тайланд тусгуулах санал хүргүүлэхээр шийдвэрлэлээ.

Б.2.2.2 Төсвийн гүйцэтгэлд тавих хяналт хангалтгүй байна.

Төсвөөс зарцуулсан хөрөнгийн гүйцэтгэл, үр дүнд аймгийн ХХААГ, аймгийн СХАА хяналт хэрэгжүүлээгүй байна.

Үндэсний хөтөлбөрүүдийн хэрэгжилтэд аймгийн ЗДТГ-ын ХШҮДАХ хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн байна.

Улсын болон орон нутгийн төсвөөс олгосон зээл, санхүүжилт, тусламжийн гүйцэтгэлд холбогдох байгууллагууд хяналт хэрэгжүүлж, төсвийн хөрөнгийн үр нөлөөг сайжруулах шаардлагатай байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- Хүнсний аюулгүй байдлын талаар төрөөс баримтлах бодлогын зорилт бүрэн хангагдахгүй, зарим арга хэмжээ болон хууль, эрх зүйн зохицуулалт бүрэн хэрэгжихгүй байгаад анхаарахаар болсон байна.
- Хүнсний аюулгүй байдлын бодлого, арга хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянах байгууллагуудын бүтэц, чиг үүргийг тодорхой болгож, ажлын уялдаа холбоог сайжруулах шаардлагатай байна.
- Хүнсний аюулгүй байдлыг бүрэн хангасан чанарын стандартыг мөрдсөн, олон улсын жишигт нийцсэн эрүүл, шим тэжээллэг хүнсний бүтээгдэхүүнээр тогтвортой хангахад анхаарахаар болсон байна.
- Төсвийг үр ашигтай төлөвлөсөн байна.
- Төсвийн хөрөнгийн зарцуулалт, гүйцэтгэлд хяналт хэрэгжээгүй байна.

Аудитаар нийт 192.5 сая төгрөгийн зөрчил илэрснээс 14.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 47.8 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 5 зөвлөмж өгч, нэгтгэсэн тайланд тусгах 130.0 сая төгрөгийн 7 саналыг хүргүүллээ.

САНАЛ:

Үндэсний аудитын газарт: Аудитаар илэрсэн дараах асуудлуудыг шийдвэрлэх талаар холбогдох газарт уламжлах. Үүнд:

1. Улсын хэмжээнд баталж буй үндэсний хөтөлбөрүүдийн хүрээнд аймаг тус бүр харилцан адилгүй дэд хөтөлбөрүүд баталж байгааг цэгцэлж, үндэсний хөтөлбөрүүдийн дагуу орон нутгийн онцлог, нөхцөл байдал, хэрэгцээг тооцож, хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө баталж хэрэгжүүлэх.
2. Зарим хүнсний техникийн зохицуулалт, шинжилгээний стандарт, стандартгүй бүтээгдэхүүний судалгаа гаргаж, нэгдсэн бодлогоор зохицуулах.
3. Хүнсний аюулгүй байдлыг хангах хууль, эрх зүйн орчныг сайжруулж, шим тэжээллэг хүнсээр тогтвортой хангахад анхаарч, хүн амд зөв дадал, хэрэглээг хэвшүүлж, таниулах.

4. Хүнсний аюулгүй байдлын бодлого, арга хэмжээг тодорхойлох, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийг хянах байгууллагуудын бүтэц, чиг үүргийг тодорхой болгож, ажлын уялдаа холбоог сайжруулах.
5. Улсын хэмжээнд үндэсний бодлогуудад мал, ургамлын гаралтай түүхий эд, хүнсний бүтээгдэхүүний цахим нэгдсэн санг бий болгох, нэгдсэн бүртгэлээр хянадаг болгох.
6. Улсын хэмжээнд лабораториудыг стандартын шаардлага хангасан ажлын байр, тоног төхөөрөмжөөр хангах асуудлыг шийдвэрлэх.
7. ЖДҮХСангаас олгосон 130.0 сая төгрөгийн зээлийг зориулалтын дагуу зарцуулаагүй, төслийг хэрэгжүүлээгүй байгаа талаар нэгдсэн тайланд тусгах.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дараах албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Засаг дарга С.Батжаргал-д

- Аймгийн Засаг даргын 2018 оны өдрийн А/325 дугаар захирамжаар баталсан “Өрхийн тариалалтыг дэмжих дэд хөтөлбөрийн хүрээнд төмс, хүнсний ногоо үр, хүлэмж олгох журам” болон 2021 онд шинэчлэн баталсан журмын эрх зүйн актын хүчинтэй байдлыг хангуулах арга хэмжээг хэрэгжүүлж, холбогдох хэлтсийн саналыг авч, шийдвэр гаргаж баталгаажуулах.
- УИХ, Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж, холбогдох хэлтэс, газрын албан тушаалтнуудын ажлын хариуцлага, ур чадварыг дээшлүүлж, шат шатны дотоод хяналтыг сайжруулах.
- Хүнсний аюулгүй байдлыг хангахад төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодын оролцоог хангуулж, тандалт судалгаа хийж, үр дүнг хэлэлцэх.
- Орон нутагт хүнсний гол нэрийн бүтээгдэхүүний болон органик, баяжуулсан хүнсний үйлдвэр, сав, баглаа боодлын үйлдвэрлэлийг бодлогоор дэмжиж ажиллах.
- Аймгийн хүнс, хоол, худалдаа эрхлэгчдийн үйл ажиллагаанд нэгдсэн хяналтын нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж, арга хэмжээний үр дүнг хэлэлцэж, байгууллагуудын ажлын уялдааг хангуулж, тайланг 2022 оны 06 сарын 15-нд ирүүлэх.

Аймгийн ХХААГ-т

- Төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд батлагдсан төсөв, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулан, үр дүнг үнэн зөв тайлагнаж, хөрөнгийг удирдан, зарцуулалтад нь хяналт тавих, шийдвэргүйгээр хөрөнгө зарцуулахгүй байх.

Аймгийн ЗДТГ-ын СТСХ-т

- Орон нутгийн дэд хөтөлбөрүүдийн батлагдсан төсвийн гүйцэтгэл, төсөвт төвлөрүүлэх орлогын төлөвлөгөөний биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилт хангахгүй төсөл хөтөлбөрүүдэд санхүүжилт олгохгүй байх.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2022 оны 06 дугаар сарын 20-ны дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

Холбогдох байгууллагын санал:

 МОНГОЛ УЛС ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА 61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум, Уртбулаг баг, Амарын талбай, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035 5590, Факс: (976) 7035 2621 И-мэйл: info@erdenet.mn дсд. 11.12 № 01/2068 танай дсд. 11.09 -ны № 210 -Т	ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ <i>В.Нарзмаа</i> <i>Тайланг батламжлуулах</i> <i>11/12</i>
Хариу хүргүүлэх тухай	
"Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн" гүйцэтгэлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцлаа. Аудитын дүгнэлтэд үндэслэн холбогдох арга хэмжээг авч "Өрхийн тариалалтыг дэмжих хөтөлбөрийн хүрээнд төмс, хүнсний ногооны үр, хүлэмж олгох журам"-ын эрх зүйн актын хүчинтэй байдлыг хангуулах, Улсын Их Хурал, Засгийн газраас хэрэгжүүлж буй бодлогын баримт бичигт дүн шинжилгээ хийж, холбогдох албан тушаалтнуудын ажлын хариуцлагыг сайжруулах, батлагдсан төсөв, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангуулан үр дүнг үнэн зөв тайлагнах, хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж ажиллах, хэрэгжилт хангалтгүй төсөл хөтөлбөрүүдэд санхүүжилт олгохгүй байхад анхаарч ажиллана. Аудитаар илэрсэн 14.7 сая төгрөгийн зөрчлийг 2022 оны 04 дүгээр сарын 15-ны дотор барагдуулна. Аудитаар өгсөн нийт зөвлөмжүүдийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх болно.	
 ЗАСАГ ДАРГА  С.БАТЖАРГАЛ	
D:\My documents\ A-4.doc 6121020967	

Саналд өгсөн тайлбар: Аудитаар илэрсэн зөрчлүүдийг хүлээн зөвшөөрсөн тул тайланд засвар оруулах шаардлагагүй гэж үзлээ.

ХАВСРАЛТУУД:**Хавсралт 1. Үндэсний хөтөлбөр, аймгийн дэд хөтөлбөрийн үнэлгээ**

д/д	Үндэсний хөтөлбөр	хөтөлбөрийн удирдлага, зохион байгуулалт	Тайлагнах явц	ХХААГ-ын үнэлгээ	ХШҮДАХ-ийн үнэлгээ	Аудитын тулган баталгаажуулсан үнэлгээ
1	Төрөөс хүнс, хөдөө аж ахуйн талаар баримтлах бодлого	тодорхой заагаагүй	жил бүр	96.5		76.3
2	Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн үндэсний хөтөлбөр	дэд хөтөлбөрийг АИТХ-аар баталж, хэрэгжилтэд хяналт тавина. АЗД хэрэгжилтийг зохион	жил бүр	100		63.8
3	Малын эрүүл мэнд үндэсний хөтөлбөр	хөтөлбөрийг АЗД, МХГ, МЭГ хариуцна.	жил бүр	100	100	80
4	Эрчимжсэн мал аж ахуйн хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр	аймагт хэрхэх талаар тусгаагүй	хэрхэн тайлагнахыг заагаагүй	100		0
5	Монгол мал үндэсний хөтөлбөр	хөтөлбөрийг АЗД, ХХААГ, МЭГ хариуцна.	жил бүр	100	94.8	94.5
6	Сав баглаа боодол үндэсний хөтөлбөр	аймагт хэрхэх талаар тусгаагүй	жил бүр	100	90	50
7	Хүнсний ногоо үндэсний хөтөлбөр	аймаг дэд хөтөлбөр боловсруулж, АЗД ахалж, ХХААГ-ын дарга н/б/д-аар ажиллана.	жил бүр	100	100	87.5
8	Жимс жимсгэнэ үндэсний хөтөлбөр	аймаг дэд хөтөлбөр боловсруулж, АЗД ахална.	жил бүр	100	100	80.00
9	Ус үндэсний хөтөлбөр	АЗД, БОАЖГ, ХХААГ хамтран гүйцэтгэнэ	2021.06 сард үнэлнэ.	83.8		
10	Ноолуур үндэсний хөтөлбөр	ХХААГ		100	90	75
11	Үйлдвэржилт 21:100 үндэсний хөтөлбөр	ХХААГ		100	94	49
				1080.3	668.8	656.1
	Аймгийн дундаж үнэлгээ			98.21	95.54	65.61

Хавсралт 2. Хүнсний үйлдвэрлэл эрхлэгчийн үйл ажиллагаанд хийсэн судалгаа

Хүнсний аюулгүй байдлыг хянах өнөөгийн тогтолцоо, төсвөөс зарцуулсан хөрөнгийн үр дүн” гүйцэтгэлийн аудитаар хүнсний үйлдвэрлэгчийн ажлын байр, үйлдвэрлэлтэй танилцахад илэрсэн зөрчил

№	Үйлдвэрлэгчийн нэр	Үйл ажиллагааны чиглэл	Илэрсэн зөрчил
1	ЭРЖИЭЧ ХХК	Талх, нарийн боов	1. Ажлын байр эрүүл ахуйн шаардлага хангахгүй, 2. Ажилчид ажлын хувцасгүй, 3. Бэлэн бүтээгдэхүүний хадгалалт, тээвэрлэлт шаардлага хангахгүй, 4. Химийн бодисын савыг үйлдвэрлэлд ашигласан
2	Жинст мандал ХХК	Даршилсан ногоо	1. Зориулалтын ажлын байргүй, 2. МХГ-т үйлдвэрлэлийн бүртгэлгүй, 3. Хаяг шошгогүй
3	Дабль голд ХХК	Цэвэр ус	1. Техникийн давхарт үйлдвэрлэл эрхэлдэг,
4	н. Бадамханд	Бууз банш	1. Хаяг шошго стандартын бус
5	Үржих таван эрдэнэ ХХК	Дайвар бүтээгдэхүүн	1. Ажлын байр эрүүл ахуйн шаардлага хангахгүй, 2. Ажилчид ажлын хувцасгүй,
6	Эргэл хайрхан цех	Талхны цех /Эрдэнэт талх/	1. Ажлын байр эрүүл ахуйн шаардлага хангахгүй, 2. Ажилчид ажлын хувцасгүй,
7	Таван Эрдэнэ ХХК	Мах нядалгааны газар	1. Ажлын байр эрүүл ахуйн шаардлага хангахгүй,
8	Идэр баялаг ХХК	Хиаман цех	1. Ажлын байр эрүүл ахуйн шаардлага хангахгүй,
9	Баяжуулагч Одод ХХК	Талх нарийн боов	1. Ажлын байр эрүүл ахуйн шаардлага хангахгүй, 2. Ажилчид ажлын хувцасгүй,
10	Намжил хишиг дүүрэн ХХК	Жаргалант талх нарийн боов	1. Ажлын байр эрүүл ахуйн шаардлага хангахгүй, 2. Ажилчид ажлын хувцасгүй, 3. Үйлдвэрлэлийн урсгал буруу

Хавсралт 3. Өрхийн тариалалтыг дэмжих дэд хөтөлбөрийн хүлэмжийн судалгаа

Он	Төрөл	Аймгийн Засаг даргын Захирамжаар олгосон		Хөнгөлөлттэй нөхцөлөөр олгосон / 50 хувийн /		Шийдвэргүй олгосон		Орон нутгийн орлогын дансанд төвлөрсөн дүн /сая төгрөг/
		тоо	сая.төг	тоо	сая.төг	тоо	сая.төг	
2017 он	Байгууллагад	1	3.2					
	Өрх	1	2.3	12	32.8	0		15.6
2018 он	Байгууллагад	10	28.2					
	Өрх	6	15.5	2	20.4	0		10.2
2019 он	Байгууллагад	2	3.5					
	Өрх	7	16.2	11	24.2	0		12.1
2020 он	Байгууллагад	4	15.0					
	Өрх	9	21.7	9	26.5	8	18.5	13.2
2021 он	Байгууллагад							
	Өрх			12	29.4	11	29.3	0
Нийт дүн	Байгууллагад	17	49.90	-	-	-	-	-
	Өрх	23	55.70	46	133.3	19	47.8	51.1